

- 8.1. Эгнээний тоог зорчих хэсэг дээрх тэмдэглэл буюу 5.10.а,б, 5.11.а,б тэмдгээр тодорхойлно. Хэрэв эдгээр тэмдэг, тэмдэглэл байхгүй бол зорчих хэсгийн оргон, автомашины оргоний хэмжээ, тэдгээрийн хажуугийн зайг харгалзан эгнээний тоог тодорхойлох богоод эсрэг ходолгоонтэй бол тухайн зорчих хэсгийн оргоний зvvн гар тал дахь тэн хагасыг эсрэг ходолгоонд зориулагдсанд тооцно.
- 8.2. Эсрэг ходолгоонтэй хоёр эгнээгээр зорчдог замд гүйцэж тvрvvлэх буюу тойрон гарахаас бусад тохиолдолд эсрэг урсгал сорохийг хориглоно.
- 8.3. Ходолгооний эгнээ нь тэмдэглэлээр тодорхойлогдсон гурван эгнээгээр зорчдог замын дунд эгнээ сорог ходолгоонтэй бол уг эгнээнд зовхон гүйцэж тvрvvлэх, тойрон гарах, зvvн гар тийш буюу буцаж эргэхийн тулд орохыг зовшоорох богоод тvvний зvvн гар талын эгнээнд урсгал сорохийг хориглоно.
- 8.4. Эсрэг ходолгоонтэй доров буюу тvvнээс олон эгнээгээр зорчдог замд эсрэг урсгал сорохийг хориглоно.
- 8.5. Суурин газрын гаднах зам буюу 5.1, 5.5 тэмдэг тавигдсан замд тээврийн хэрэгсэл зорчих хэсгийн баруун гар талын захад аль болох ойр явах богоод баруун гар талын эгнээ чолоотэй байхад (зvvн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд) тvvний зvvн гар талын аль ч эгнээгээр явахыг хориглоно.
- 8.6. Суурин газарт жолооч энэ дvрмийн 8.7-8.10, 23.4-т заасан шаардлагуудыг зорчихгvйгээр аль тохиромжтой эгнээг сонгож явна. Ходолгооний эрчим ихтэй (эгнээ чолоогvй) замд эргэх вйлдэл хийх, саадыг тойрон гарах, зогсохоос бусад тохиолдолд эгнээ байр оорчлохийг хориглоно.
- 8.7. Нэг чигт гурав буюу тvvнээс олон эгнээгээр зорчдог замын тухайн чигийн хамгийн зvvн гар талын эгнээнд зовхон гүйцэж тvрvvлэх, зvvн гар тийш болон буцаж эргэхийн тулд, мон ходолгооний эрчим ихтэй (бусад эгнээнууд чолоогvй) вед байр эзлэхийг зовшоорно. Харин бvх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин зовхон зvvн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд уг эгнээнд орохыг хориглоно. Дээрх зам нь нэг чигийн ходолгоонтэй бол тvр зогсохын тулд хамгийн зvvн гар талын эгнээнд орохыг зовшоорно.
- 8.8. Трактор, оороо явдаг машин механизм болон цагт 40 км-ээс илvvгvй хурдтай явах тээврийн хэрэгсэл гvйцэж тvрvvлэх, тойрон гарах, зvvн гар тийш буюу буцаж эргэхийн тулд байр эзлэхээс бусад тохиолдолд зорчих хэсгийн хамгийн баруун гар талын эгнээгээр явна.
- 8.9. Тууш замд бvх жин нь 3.5 тонноос их ачааны автомашин зорчих хэсгийн баруун гар талын нэг буюу хоёр дахь эгнээгээр явна.
- 8.10. Троллейбусны жолооч омных троллейбус шугамнаас салаагvй байхад зэрэгцээ эгнээнд орохыг хориглоно.
- 8.11. Жолооч нь урдаа яваа тээврийн хэрэгсэл зогсоход тvvнийг моргохгvй, хажуу дахь тээврийн хэрэгслийг шvргэхгvй байх хэмжээний хоорондын болон хажуугийн зайг ходолгооний хурднаас хамааруулан сонгож явна.

//